

Улсын Бүртгэлд бүртгүүлэх бичиг баримт

ХАРЬАЛАЛ ХАРГАЛЗАХГҮЙ

10 БҮРТГЭЛ

1. Төрсний
2. Гэрлэсний
3. Гэрлэлт дуусгавар болсны
4. Гэрлэлт сэргээсний
5. Иргэний байнга оршин суугаа газрын хаягийн
6. Эцэг эх тогтоосны
7. Нас барсны
8. Иргэний үнэмлэхийн
9. Иргэний үнэлэх дахин захиалах
10. Үндэсний гадаад паспорт, түүнийг орлох бичиг баримт

Шинээр төрсөн хүүхдийг төрсний бүртгэлд

бүртгүүлэхэд бүрдүүлэх материал

- ЭМТ-өөс СТ-4 маягт
- Өргөдөл, /хүүхэд бүртгүүлхийг хүссэн/
- Эцэг эхийн иргэний үнэмлэх
- Эцэг эхийн гэрлэлтийн гэрчилгээ
- Гэрлэсний гэрчилгээгүй бол эцэг эхийн хамтран гаргасан өргөдөл

Шинээр төрсөн хүүхдийг эцэг, эхийн оршин суугаа газрын, эсхүл хүүхдийн өөрийнх нь төрсөн газрын сум дүүргийн улсын бүртгэлийн байгууллагад төв суурин газарт **15**, хөдөө орон нутгийн алслагдсан сум, багт **30** хоногийн дотор хандан үнэ төлбөргүй бүртгүүлнэ. Хугцаандаа бүртгүүлээгүй тохиолдолд **20000** төгрөгийн торгууль төлнө

16 насанд хүрсэн иргэн иргэний үнэмлэх анх удаа

авахдаа

- Төлбөр төлсөн баримт
- Эцэг эхийн иргэний үнэмлэх
- Биеийн давхцахгүй өргөдлийн бүртгэлд бүртгүүлэхдээ заавал өөрийн биеэр оршин суугаа сум, дүүргийн улсын бүртгэлийн хэлтэст хандана.
- Иргэний үнэмлэхийг **30** хоногын дотор захиалах бөгөөд хугацаа хэтэрвэл **20000₮** ийн торгууль төлнө.

Иргэний үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгах

- Төлбөр төлсөн баримт
- Аймаг, сумын бүртгэлийн хэлтэст биечлэн очиж зургаа шинээр авхуулан, хурууны хээгээ өгнө
- **25, 45** насны сунгалтыг **30** хоногын дотор сунгуулах бөгөөд хугацаа хэтэрвэл **20000₮** ийн торгууль төлнө.
- Хаяж үрэгдүүлсэн, гэмтээсэн тохиолдолд **30000₮** торгууль төлнө.

ХАРЬАЛАЛ ХАРГАЛЗАХ 5 БҮРТГЭЛ

1. МУ-ын харьяат болсон, харьяатаас гарсан, иргэний харьяаллыг сэргээн тогтоосны
2. Хүйс өөрчлөгдсөний
3. Овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний
4. Шилжилт хөдөлгөөний
5. Үрчилсний

Гэрлэсний бүртгэлд бүртгүүлэхэд

- Гэрлэлтээ батлуулахыг хүссэн тухай өргөдөл
- Гэрлэсэн эсэх лавлагаа. УБЕГ-ын ИБА-аас авна
- Гэрлэгсдийн иргэний үнэмлэх
- Өмнө нь гэрлэж, гэр бүл цуцалсан бол гэрлэлт цуцлалтын гэрчилгээ
- Иргэний баримтын архивын лавлагаа.
- Эрүүл мэндийн тодорхойлолт гаргуулах /дох, сэтгэц, сүрьеэ/
- Гэрчилгээний үнэ **2500₮**

Гэрлэлт бүртгүүлж буй хосууд өөрийн биеэр оршин суугаа сум, дүүргийн улсын бүртгэлийн байгууллагад хандана.

Шилжилт хөдөлгөөний бүртгэлийг бүртгэхэд

- Иргэний үнэмлэх /16-аас доош насны хүүхэдтэй бол хүүхдийн гэрчилгээ/
- Тухайн хаягт оршин суух Хороо Бууц, Газарийн гэрчилгээ хуулбар
- Эзэмшигчийн иргэний үнэмлэхний хуулбар
- Талуудын өргөдөл
- Үнэ: Аймаг нийслэл дотор **2500₮**

Нийслэлээс аймаг **5000₮**

Багаас багт **1500₮**

Зөвхөн тухайн оршин суух сум харьяандаа бүртгүүлнэ.

Нас барсны бүртгэлд бүртгүүлэхдээ

- ✓ Нас барсан тухай АМ-7 маягт ЭМТ-өөс авч иргэх
- ✓ Иргэний үнэмлэхийн хамт

Нас барсны бүртгэлийн аймаг нийслэлд 3, Сум хөдөө орон нутагт 7 хоногийн дотор бүртгүүлнэ.

Вэб: www.burtgel.gov.mn

Нээлттэй утас: 88625784



Улсын Бүртгэлд бүртгүүлэх бичиг баримт

Газар амчлөх эрхийг улсын бүртгэлд анх удаа бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичиг

- Бүртгүүлэхийг хүссэн өргөдөл /өргөдөлд тухайн газрын хаяг, хэмжээ, үнэ, нэгж талбарын дугаар, хэдэн хүн хамтран өмчилдөг тухай тодорхой бичиж гарын үсгээ зурсан байна./
- Газар өмчлүүлэх тухай шийдвэр /ГХБХБГ-ын хуулбар үнэн тэмдэг дарсан байх/
- Хянан баталгааны дүгнэлт
- Кадастрын зураг /эх хувь/
- Өмчлөгчдийн иргэний үнэмлэх, насанд хүрээгүй бол төрсний гэрчилгээний хуулбар
- Үйлчилгээний хураамж үнэ төлбөргүй
- Мэдүүлэг бөглөнө

Мэдүүлэгт дээр дурдсан нотлох баримтуудыг хавсарган хүлээлгэн өгнө. Мэдүүлэг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор бүртгэх эсэх хариу мэдэгдэнэ

Хашаа байшин, хувийн сууц өмчлөх эрхийг улсын бүртгэлд анх удаа бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичиг

- Бүртгүүлэхийг хүссэн өргөдөл /өргөдөлд хэдэн онд хэн барьж, бий болгосон, одоо хэдэн хүний хамтын өмч болох, эд хөрөнгийн хаяг, байршил, хэмжээ, үнийг өмчлөгч өөрөө тодорхой бичиж, гарын үсгээ зурсан байна./
- Газар өмчлөх эрхийн гэрчилгээ, эсхүл газар эзэмших эрхийн гэрчилгээ, газар эзэмших гэрээний хуулбар.
- Хашаа байшин, хувийн сууцыг 4 талаас нь бүтэн харагдуулж авсан фото зураг/А4 цаасан дээр нааж тайлбар бичих, нэг хашаанд 2 ба түүнээс дээш байшинтай бол нэг зурагт бүгдийг нь багтааж авах/
- Хашаа байшин, хувийн сууцны план зураг /талбайн хэмжээ тусгах, компьютер дээр тодорхой байдлаар зурсан байх/
- Тэмдэгтийн хураамж: эд хөрөнгийн үнийн дүнгийн **0,01** хувиар тооцох
- Хэрэв ам бүл 1-ээс дээш гишүүнтэй бөгөөд үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээг **1** иргэний өмчлөлд бүртгүүлэх бол бусад хамтран өмчлөгчийн татгалзсан өргөдлийг нотариатаар батлуулж мэдүүлэгт хавсаргана.
- Мэдүүлэг бөглөнө

Худалдах – худалдан авах, бэлэглэх гэрээг улсын бүртгэлд бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичиг

- Худалдах, худалдан авах, бэлэглэх гэрээ //эд хөрөнгө оршин байгаа нотариатаар гэрчлүүлж, гэрээнд оролцогч талуудын иргэний үнэмлэх, насанд хүрээгүй бол төрсний гэрчилгээний хуулбар, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ гэрээ, дүрмийн хуулбарыг хавсаргана.
- Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ /эх хувь/
- Худалдах худалдан авахгэрээ хийсэн тохиолдолд хөрөнгө оршин байгаа тухайн харьяаны татварын хэлтэст гэрээний үнийн дүнгийн **2** хувиар хураамж төлсөн баримт
- Үйлчилгээний хураамж: Энгийн **20000₮** төгрөг
- Мэдүүлэг бөглөнө

Бэлэглэх гэрээг улсын бүртгэлд бүртгүүлж өгөх баримт бичгүүд

- ✓ Гэрээнд оролцогч талуудын иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээний хуулбар
- ✓ Бэлэглэх гэрээ /хотариатаар гэрчлүүлсэн байна/
- ✓ Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ /эх хувь/
- ✓ Үйлчилгээний үнэ **20000₮**
- ✓ Мэдүүлэг бөглөнө.

Вэб: www.burtgel.gov.mn
dundgovi.burtgel.gov.mn
Асуух утас: 88625784

